
Хамтдаа хэрэгжүүлэх, эрэг хүмүүжил

Бүгд Найрамдах Солонгос Улсад хүүхдийг аюулгүй, эрүүл өсгөн хүмүүжүүлэхэд зориулсан хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, мэдээлэх болон дэмжлэг авах талаарх гарын авлага

- **Насанд хүрсэн гадаад иргэнд зориулсан**



Бүгд Найрамдах Солонгос Улсад бүх хүүхэд аюулгүй өсөж хөгжих эрхтэй. Эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийг хамгаалж, өсгөн хүмүүжүүлэх үүрэгтэй бөгөөд төр болон орон нутгийн хамтын нийгэмлэг нь хүүхэд, гэр бүлийг дэмжих төрөл бүрийн үйлчилгээг үзүүлдэг. Энэхүү танилцуулгад Бүгд Найрамдах Солонгос Улсад оршин суудаг эцэг эх, асран хамгаалагчдын мэдэж байвал зохих тогтолцоо болон дэмжлэгийн талаарх мэдээллийг танилцуулна.

Ministry of Health and Welfare

NCRC National Center for the Rights of the Child

Бүгд Найрамдах Солонгос Улс дахь хүүхдийн эсрэг хүчирхийллийн ойлголт, төрлүүдийг ойлгох

Хүүхэд бүр хүчирхийлэл, үл хайхрах байдал, дарамтгүйгээр аюулгүй өсөж хөгжих эрхтэй. Улс орон, соёлын онцлогоос шалтгаалан хүүхэд өсгөн хүмүүжүүлэх арга барил өөр байж болох ч Бүгд Найрамдах Солонгос Улсад хүүхдэд бие махбодын шийтгэл оногдуулахыг огт зөвшөөрдөггүй бөгөөд хүүхдийг хүндэтгэж, ярилцан ойлголцох замаар өсгөн хүмүүжүүлэхийг зөвлөдөг.

Бүгд Найрамдах Солонгос Улсад "хүүхдийн эсрэг хүчирхийлэл" гэж юуг хэлдэг вэ?

Бүгд Найрамдах Солонгос Улсад хүүхдийн өсөлт, хөгжилд саад учруулах, эсвэл бие махбодын болон сэтгэл санааны шарх учруулах үйлдлийг хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж үздэг. Эцэг эх, асран хамгаалагчид ч мөн энэхүү шалгуурт хамаарна.

("Хүүхдийн халамжийн тухай хууль"-ийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт)

Бүгд Найрамдах Солонгос Улсад хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж үзэж болох үйлдлүүд

1.Бие махбодын хүчирхийлэл

Санамсаргүй ослын бус нөхцөлд хүүхдийн биед гэмтэл учруулах, эсвэл биеийн эрүүл мэнд, хөгжилд нь хор хөнөөл учруулах бүх үйлдэл



- Хүүхдийг цохих, хазах үйлдэл
- Эд зүйл эсвэл хүч хэрэглэн хүүхдийн биед заналхийлэх үйлдэл
- Түлэх, эсвэл биед нь гэмтэл учруулах үйлдэл

2.Сэтгэл санааны хүчирхийлэл

Хүүхдийг үг хэлээр доромжлох, сэтгэл санааны хувьд заналхийлэх, хорих буюу үндэслэлгүйгээр эрх чөлөөг нь хязгаарлах болон бусад хэрцгий харьцах үйлдэл



- Хүүхдийг доромжлох эсвэл байнга шүүмжлэх
- Тодорхой нэг хүүхдийг ялгаварлан гадуурхах (ах, эгч, дүү эсвэл найз нөхдийнх нь дунд харьцуулах, ялгаварлан гадуурхах, илүү тал засах)
- Тухайлбал, хүүхдийг гэр бүлийн хүчирхийллийн нөхцөлд байлгах замаар түүнд айдас, түгшүүр төрүүлэх

3.Бэлгийн хүчирхийлэл

Хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэх, ийм үйлдлийг зохион байгуулах, хүүхдэд бэлгийн дарамт үзүүлэх зэрэг хүүхэд оролцсон аливаа бэлгийн үйлдэл



- Хүүхдийг ажиглах эсвэл бэлгийн дур хүслээ хангахын тулд өөрийгөө хүүхдэд үзүүлэх
- Хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртүүлэх, эсвэл хүүхэдтэй бэлгийн харьцаанд орохтой адилтгах үйлдэл хийх
- Хүүхдийг биеэ үнэлэхэд хүргэх, эсвэл хүүхдийг оролцуулан биеэ үнэлэхийг зохион байгуулах

4.Хайхрамжгүй хандах

Хүүхдийн хоол, хувцас, орон байр зэрэг амьдралын үндсэн хэрэгцээ, хамгаалал, асран халамж, эмчилгээ, боловсролыг үл хайхарч, эсвэл хүүхдийг хамгаалалтгүй байдалд оруулснаар амь нас, эрүүл мэндэд нь аюул учруулах үйлдэл



- Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүүхдийг сургуульд явуулахгүй байх, эсвэл боловсрол эзэмших боломжийг нь хязгаарлах үйлдэл
- Хүүхдэд шаардлагатай хоол хүнс, хувцас, эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэхгүй байх үйлдэл
- Хүүхдийн төрсний бүртгэлийг хийхгүй байх үйлдэл
- Хүүхдийг гэрт нь ганцаарангүй орхих, эсвэл хамгаалалтгүй байдалд үлдээх үйлдэл

Тусламж хэрэгтэй байж болзошгүй хүүхдийн шинж тэмдэг


Хэрэв хүүхэд дараах шинж тэмдгийг үзүүлж байвал тусламж хэрэгтэй байгаагийн дохио байж болно.

- Учир шалтгааныг нь тайлбарлахад бэрх гэмтэл, эсвэл гэмтэхэд амаргүй хэсэгт байнга шарх, гэмтэл илрэх
- Хэт их аймхай, дуугүй болох, эсвэл түрэмгий зан авир гаргах
- Сургууль таслах, гэрээсээ дайжих, эсвэл оройтож гэртээ харих явдал байнга давтагдах
- Байнга өлссөн байх, ариун цэвэр хангалтгүй байдалтай харагдах, эсвэл өвчтэй мэт эрүүл мэндийн байдалтай байх

Бүгд Найрамдах Солонгос Улсаас зөвлөж буй “Эерэг хүмүүжил ”

Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газраас эцэг эх, хүүхэд харилцан бие биеэ хүндэтгэж, эрүүл саруул өсөж хөгжихөд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор эерэг хүмүүжлийг зөвлөж байна. Эерэг хүмүүжил гэдэг нь хүүхдийг бие даасан хувь хүн хэмээн хүндэтгэж, эцэг эх, хүүхдийн хооронд харилцан яриа, ойлголцолд үндэслэн харилцаагаа бүрдүүлэх хүмүүжлийн арга юм. Эерэг хүмүүжлийг хэрэгжүүлэхэд зориулсан “Эерэг хүмүүжлийн 129 зарчим”-ыг танилцуулж байна.

Эерэг хүмүүжлийг хэрэгжүүлэх арга, “Эерэг хүмүүжлийн 129 зарчим”





1. Хүүхдээ таньж мэдэх

Хүүхэд бүрийн төрөлхийн зан төлөв, зан чанар өөр бөгөөд өсөлт, хөгжлийн онцлог нь ч харилцан адилгүй байдаг. Тиймээс хүүхдээ сайтар ажиглаарай.


(Жишээ) Танихгүй хүнээс их бишүүрхдэг хүүхдэд дасан зохицох хугацаа өгч, хүлээх



2.өрийгөө эргэцүүлэн харах

Эцэг эхийн хувьд өөртөө ямар онцлог, мөн сайжруулах шаардлагатай зүйл байгаа талаар эргэцүүлэн бодоорой.

(Жишээ) Хүүхэд алдаа гаргасан үед уурлахаасаа өмнө рийн сэтгэл хөдлөлийг эхлээд анзаарах



3. Өөр өнцгөөс харах

Хүүхдийн асуудалтай зан үйл гэж бодож байсан зүйл үнэхээр засах шаардлагатай эсэхийг өөр өнцгөөс харж үзээрэй.

(Жишээ) Хүүхэд байнга асуулт асууж байгааг сониуч зангийн илэрхийлэл гэж ойлгох



4. Хамтдаа өсөж хөгжих

Эцэг эхийнхээ үүргийг хүүхдийн өсөлт, хөгжлийн онцлогт тохируулан өөрчилж байгаарай.


(Жишээ) Хүүхдийн өсөлт, хөгжилд тохируулан өөрөө бэлтгэж, өөрөө сонголт хийх боломжийг нь нэмэгдүүлэх



5. Бүрэн анхаарал хандуулах

Хүүхэдтэйгээ хамт өнгөрүүлж буй цагт зөвхөн хүүхэддээ бүрэн анхаарлаа хандуулаарай.

(Жишээ) Хүүхэдтэйгээ ярилцаж байх үедээ гар утсаа түр хойш тавих



6. Анхааралтай сонсож, сэтгэл санааг нь ойлгох

Хүүхдийнхээ үзэл бодол, санаа бодлыг анхааралтай сонсож, сэтгэл хөдлөлийг нь ойлгон хамт мэдрээрэй.

(Жишээ) Найзтайгаа маргалдсан хүүхдийн гомдсон сэтгэлийг нь хангалттай сонсож, сэтгэл санааг нь ойлгон хамт мэдрэх



7. Тууштай байх

Хүүхэд зөвшөөрч болох амлалт, дүрмийг хамтдаа тогтоож, түүндээ тууштай хандаарай.

(Жишээ) Хүүхэдтэйгээ хамт тогтсон унтах цагийг тогтмол мөрдөх



8. Алдаагаа хүлээн зөвшөөрөх

Эцэг эх ч заримдаа алдаа гаргаж болдгоо хүлээн зөвшөөрч, уучлал хүсээрэй.

(Жишээ) Агшин зуурын сэтгэл хөдлөлөөсөө болж уурласан бол хүүхдээдээ алдаагаа хүлээн зөвшөөрч, эхлээд уучлал хүсэх




9. Хамтдаа өсгөн хүмүүжүүлэх

Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх нь зөвхөн эцэг эхийн үүрэг биш юм. Хэцүү үедээ ойр дотнын хүмүүс эсвэл мэргэжлийн хүмүүст хандан тусламж хүсээрэй.


(Жишээ) Хүүхэд өсгөн хүмүүжүүлэхэд хүндрэлтэй санагдах үед Хүүхэд асрах цогц дэмжлэгийн төв зэрэг мэргэжлийн байгууллагаас тусламж авах

БНСУ-д хүүхдийн аюулгүй байдлыг хэн хамгаалдаг вэ?



БНСУ-д гэр бүл, сургууль, орон нутгийн хамт олон болон төр хамтран хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалдаг.

Хүүхдийн аюулгүй байдлыг анхааран хамгаалдаг хүмүүс — “Хүүхдийн хүчирхийллийг мэдээлэх үүрэг бүхий этгээд”




- Багш, хүүхэд асрах төв болон цэцэрлэгийн багш, ажилтан, эмнэлгийн ажилтан зэрэг хүмүүс хүүхдүүдтэй байнга уулзаж, тэдний өсөлт хөгжил, эрүүл мэндийн байдлыг ажиглан шалгадаг. Тэд хүүхэд аюулд өртсөн эсвэл хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй гэж сэжиглэсэн тохиолдолд холбогдох байгууллагаас (112) тусламж хүсэж болно.
- Энэ нь эцэг эхийг шийтгэх зорилготой бус, харин хүүхдийн аюулгүй байдлыг шалгаж, шаардлагатай дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн тогтолцоо юм.

※ 「Хүүхдийн хүчирхийллийг шийтгэх тухай хууль」-ийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүүхдийг хамгаалах чиг үүрэг бүхий нийт 27 төрлийн мэргэжил, албан тушаал хамаарна.

Хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалдаг хүмүүсийг хамгаалах тогтолцоо — “Хүүхдийн хүчирхийллийн талаар мэдээлэгчийг хамгаалах”





БНСУ-д хүүхдийн хүчирхийллийн талаар мэдээлсэн эсвэл зөвлөгөө хүссэн хүний мэдээллийг хуульд заасны дагуу хамгаалдаг.

Хэн ч мэдээлэгчийн хувийн мэдээлэл, эсвэл тухайн хүнийг мэдээлэгч болохыг мэдэж болохуйц аливаа мэдээллийг бусдад дамжуулах, нийтэд ил болгохыг хориглоно. Мөн мэдээлэл өгсөн шалтгаанаар түүнд ямар нэгэн хохирол, ялгаварлан гадуурхалт учруулж болохгүй. Үүнийг зөрчсөн тохиолдолд хуульд заасны дагуу шийтгэл хүлээж болно.

※ 「Хүүхдийн хүчирхийллийг шийтгэх тухай хууль」-ийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 2-т заасны дагуу.



Хүүхдийн хүчирхийлэл үйлдэгдсэн байж болзошгүй гэж сэжиглэвэл ямар арга хэмжээ авдаг вэ?

БНСУ-ын хүүхэд хамгааллын тогтолцоо нь эцэг эх, асран хамгаалагчийг шийтгэх зорилготой бус, харин хүүхдийн аюулгүй байдлыг шалгаж, тухайн хүүхдийн гэр бүл эсвэл асран хамгаалагчид шаардлагатай дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн тогтолцоо юм.

Хүүхдийн хүчирхийллийн тохиолдлыг шийдвэрлэх үйл явц



1. Мэдээлэл хүлээн авах эсвэл зөвлөгөө өгөх

24 цагийн турш ажилладаг мэдээлэл хүлээн авах утас (112)-аар дамжуулан зөвлөгөө авах хүсэлт эсвэл мэдээллийг хүлээн авна.

2. Хүүхдийн аюулгүй байдлыг шалгах болон нөхцөл байдлыг судлах

Цагдаагийн алба хаагч болон хүүхдийн хүчирхийлэл хариуцсан төрийн албан хаагч хамтран газар дээр нь очиж, хүүхдийн аюулгүй байдлыг шалган, шаардлагатай мэдээллийг судална.





3. Тохиолдлын талаар дүгнэлт гаргах

Судалгааны үр дүнд үндэслэн хүүхдэд хамгаалалт шаардлагатай нөхцөл байдал үүссэн эсэхийг тогтооно.

4. Хамгаалалт болон дэмжлэг үзүүлэх

·Шаардлагатай тохиолдолд хүүхдэд хамгаалалт, эмнэлгийн тусламж үйлчилгээ, зөвлөгөө, сэтгэл зүйн эмчилгээ зэрэг үйлчилгээ үзүүлнэ.
·Мөн гэр бүл болон асран хамгаалагчид зөвлөгөө, сургалт, сэтгэл зүйн эмчилгээ зэрэг төрөл бүрийн нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлж болно.






5. Тогтмол хяналт, дэмжлэг

Хүүхэд болон гэр бүл (эсвэл асран хамгаалагч)-ийг аюулгүй, эрүүл амьдралаа үргэлжлүүлэхэд нь шаардлагатай дэмжлэгийг үргэлжлүүлэн үзүүлнэ.

Хүүхдийн хүчирхийллийг хэрхэн мэдээлэх вэ



Хүүхдийн аюулгүй байдалд санаа зовж байгаа эсвэл хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд хүндрэл тулгарсан үедээ та хүссэн үедээ тусламж хүсэх боломжтой.

Хүүхдийн аюулгүй байдалд санаа зовж байгаа үед мэдээлэх болон зөвлөгөө авах байгууллагууд



Цагдаа 112

Хүүхдийн хүчирхийллийн талаар мэдээлэл хүлээн авах, мөрдөн шалгах

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны дуудлагын төв 129

129 дугаарт залгаад 6 дугаарыг сонговол хүүхдийн хүчирхийллийн талаар зөвлөгөө авна.



Си/Гүн/Гү (Хот, сум, дүүрэг) байгууллага

Хүүхдийн хүчирхийллийн талаарх мэдээлэл хүлээн авах болон зөвлөгөө өгөх, хүүхдийн хүчирхийллийн нөхцөл байдлыг шалгах, хамгаалалт болон дэмжлэг үзүү

Хүүхэд хамгааллын мэргэжлийн байгууллага

Хүчирхийлэлд өртсөн хүүхэд болон түүний гэр бүлд хамгаалалт, зөвлөгөө үзүүлэх



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага 1644-8295

Хүчирхийлэлд өртсөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зөвлөгөө өгөх, нөхцөл байдлыг шалгах, хамгаалалт болон дэмжлэг үзүүлэх

Danuri дуудлагын төв 1577-1366

Хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой асуудлаар олон соёлт гэр бүлд зөвлөгөө өгөх, орчуулгын үйлчилгээ үзүүлэх, хамгаалалт болон дэмжлэг үзүүлэх

※ Хүүхэд эсвэл хүүхдийн хүчирхийлэл үйлдсэн байж болзошгүй хүний талаарх мэдээллийг бүрэн мэдэхгүй байсан ч мэдээлэх боломжтой.

Холбогдох байгууллагуудын мэдээлэл

Эцэг эх болон гэр бүлд зориулсан дэмжлэг үзүүлэх байгууллагууд



1 Онлайн дэмжлэг үзүүлэх байгууллагууд

Хүүхдийн эрхийн үндэсний хүрээлэн (National Center for the Rights of the Child) (02-6454-8500, www.ncrc.or.kr)

Хүүхдийн сайн сайхны үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагааг нэгдсэн байдлаар хэрэгжүүлэх, бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх

Ай-Саранг (i-Sarang) (www.childcare.go.kr)

Жирэмслэлт, төрөлт, хүүхэд өсгөн хүмүүжүүлэх, хүүхэд асрах төв/цэцэрлэгийн үйлчилгээний талаарх мэдээлэл болон мэргэжлийн зөвлөгөө үзүүлэх

Сайн эцэг эх, аз жаргалтай хүүхэд (Good Parents, Happy Children) (www.mogef.go.kr/kps/main.do)

Жирэмслэлт, төрөлт, хүүхэд өсгөн хүмүүжүүлэх, хүүхэд асрах төв/цэцэрлэгийн үйлчилгээний талаарх мэдээлэл болон мэргэжлийн зөвлөгөө үзүүлэх

Эцэг эх On Нури (Parents On Nuri) (www.parents.go.kr)

Бие даан суралцах чадвар, мэргэжил сонголт ба дээд боловсролд элсэлт, бүтээлч байдал, ёс суртахууны боловсрол зэрэг хүүхдийн боловсролтой холбоотой агуулга хүргэх

Бокжиро (Bokjiro) (www.bokjiro.go.kr)

Амьдралын үе шат бүрт тохирсон нийгмийн халамжийн тогтолцооны талаарх мэдээлэл өгөх болон үйлчилгээний хүсэлт гаргах боломж олгох

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын зөвлөгөөний төв (Health and Welfare Counseling Center) (129, www.129.go.kr)

Яаралтай нийгмийн халамжийн дэмжлэг, сэтгэцийн эрүүл мэнд, хүүхдийн хүчирхий лэлтэй холбоотой хямралын үед зөвлөгөө өгөх болон мэдээлэл хүргэх



2 Офлайн дэмжлэг үзүүлэх байгууллагууд

Хүүхэд асрах үйлчилгээний төв байгууллага (Central Support Center for Childcare) (1577-0756, https://central.childcare.go.kr)


Эцэг эхэд зориулсан сургалт, зөвлөгөө, тоглоом болон ном түрээслэх үйлчилгээ, тоглонгоо хөгжих танхим ажиллуулах зэрэг хүүхэд өсгөн хүмүүжүүлэх үйлчилгээ үзүүлэх

Гэр бүлийн төв (Family Center) (1577-9337, www.familynet.or.kr)

Гэр бүлийн боловсрол, зөвлөгөө, гэр бүлийн чадавхыг бэхжүүлэх дэмжлэг, гэр бүлийн асаргаа халамжийг хамтран хэрэгжүүлэх, хамтын хүүхэд асрах орчин ажиллуулах, хүүхэд асрах үйлчилгээ үзүүлэх зэрэг асаргаа, халамжийн үйлчилгээг дэмжих

Олон соёлт гэр бүлийг дэмжих портал Данури (Multicultural Family Support Portal Danuri) (1577-1366, www.liveinkorea.kr)

Олон соёлт гэр бүлд зөвлөгөө өгөх болон дэмжлэгийн хөтөлбөрийн талаар мэдээлэл өгөх



Эцэст нь, БНСУ-д хүүхдээ өсгөн хүмүүжүүлж буй эцэг эхчүүдэд

БНСУ нь хүүхдийн аюулгүй байдал, эрхийг нэн тэргүүнд тавьдаг бөгөөд эцэг эх, гэр бүл хүүхдээ эрүүл саруул өсгөн хүмүүжүүлэхэд нь зориулан төрөл бүрийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг санал болгодог.
Хүүхдийн аюулгүй байдалд санаа зовж байгаа эсвэл хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд хүндрэл тулгарч, тусламж хэрэгтэй үедээ хүссэн үедээ тусламж хүсээрэй. БНСУ нь та бүхний хүүхэд болон гэр бүлийг эрүүл, аюулгүй өсөж хөгжихөд хамтран дэмжих болно.